

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **“Гүүрэн болон вандан крануудын цахилгаан тоног төхөөрөмж, удирдлагын шинэчлэл” нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112097

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **“Гүүрэн болон вандан крануудын цахилгаан тоног төхөөрөмж, удирдлагын шинэчлэл”** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 %-иас багагүй байна.**

Тендерийн хамт **2 300 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхтэй**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 508 тоот өрөө,

утас: 450060 + 177

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ